



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 024

Жаргалтхаан сум

┌ Т.Энхсайханыг туршилтын хугацаагаар
томилох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 50 дугаар зүйлийн 50.1.2, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын 1, 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИАРМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газар, сан хариуцсан нягтлан бодогчоор Төртогтохын Энхсайханыг 2025 оны 06 дугаар сарын 02 –ны өдрөөс эхлэн туршилтын хугацаагаар түр томилсугай.

2.Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн гишүүд: 3.Жанчив-Төсөвт байгууллагын төлбөр тооцоо

хариуцсан мэргэжилтэн

Г.Түмэнжаргал- Байгаль орчны асуудал хариуцсан

мэргэжилтэн

Д.Мөнхбаяр- нярав


3.Ажил хүлээлцэх акт үйлдэн чанартай хүлээлцүүлэхийг 3.Жанчивт, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллахыг Т.Энхсайханд үүрэг болгосугай.

2.

4. Нягтлан бодогч Т.Энхсайханыг ТҮМ-7-р шатлал 1,559,000 (нэг сая таван зуун тавин есөн мянга) төгрөгөөр цалинжуулж, орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч Т.Энхсайханд зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн Б/19 дугаартай захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



С.ГАНБАТ